

БАТЛАВ:

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын дарга  
B.Пүрэвтулга /  
2017 оны .... сарын ....өдөр  
ТТБ9188 № 9048227

БАТЛАВ:

"Энержи ресурс ХХК -ий дэд  
өрөнхийлөгч ENERGY  
RESOURCES LLC  
2017 оны 03 сарын 10 өдөр  
Ц.Баасандорж /  
УЛААНбаатар хот. 28871

### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2017 оны 03 сарын 29 -ний өдөр

Дугаар 001

Даланзадгад

#### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь заалт, Галба Өөш долоодын говийн сав газрын захирагааны 2017 оны 03 сарын 02-ний өдрийн 01 дугаартай Ус ашиглуулах дүгнэлт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 03 сарын 29-ний өдрийн а/10 тоот тушаалыг тус тус үндэслэн:

Нэг талаас Ус ашиглуулагчийг төлөөлж Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн Тэрбиш овогтой Соёлмаа, негеэ талаас ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сэнтрал тауэр, 16 давхар хаягт орших Энержи ресурс ХХК \ улсын бүртгэлийн дугаар 9011007001, регистрийн дугаар 2887746\ -ийн Төрийн байгууллагын харилцаа зөвшөөрөл хариуцсан захирал Заанхүү овогтой Сугармаа нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатай байгуулав.

#### Хоёр. Гэрээний гол нөхцөл

##### 2.1. Ус ашиглах зориулалт :

- Унд ахуйн
- Зам талбайн усалгаа
- Хулуун ус, душ
- Ногоон байгууламж

##### 2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. Унд ахуй – 7008м<sup>3</sup>/жил

2.2.2. Халуун ус, душ - 15552м<sup>3</sup>/жил

2.2.3 Зам талбайн усалгаа -1166м<sup>3</sup>/жил

2.2.4 Ногоон байгууламж усалгаа- 1280м<sup>3</sup>/жил

2.2.5 Нийт ашиглах усны хэмжээ 25006 м<sup>3</sup>/жил

2.3 Усны чанар, найрлага: Унд ахуйн уснаас дээж авч улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг БОАЖГазарт ирүүлэх

2.4 Усны эх үүсвэр:

Байршил	Ханбогд сумын Жавхлант, Хайрхан баг
Солбицол	CR -9 худаг 47 23 72,5 69 12 67 CR -10 худаг 47 16 384, 759 709786,425
Барилга байгууламж	3х4 хэмжээтэй сэндвичэн барилгатай, 10м <sup>3</sup> багтаамжтай ус нөөцлөх сав 1 ширхэг
Тоног төхөөрөмжийн нэр, марк	CR -9 худаг FS982-A/11 маркийн ус өргөгч, SAER-0,55kw маркийн хөдөлгүүр

2.5 Хаягдал усны: Унд ахуйн хэрэгцээнд ашигласан уснаас гарах хаягдал усны хэмжээ, чанар найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэрэгт улирал тутам шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг БОАЖГазарт ирүүлэх

2.6 Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргав.

Жинлэгдэх бодис, кг.....  
Органик бодис, кг .....

Эрдэс бодис, кг.....

Хүнд металл, кг .....

Аюултай бохирдуулах, бодис, кг .....

2.7 Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин

Хаягдал ус зайлцуулах цэгийг сумын Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн а/80 захирамжаар N42°33'00" E107°28,7'47" Солбилицолд 0,5 га хэмжээтэй олгосон байна.

2.8 Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдооос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцагч
1.	Зөөврийн болон түр нөөцлөх савнуудад угаалга халдвартгуйжүүлэлт хийлгэх			
2.	Усны эх үүсвэрт хими бактерлогийн шинжилгээг тогтмол хийлгэж МХГ-ын			

	Улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах			
3.	Ажилчиддаа усыг хэмнэх, хамгаалах талаархи сургалт зохион байгуулах			
4.	Усны асуудал хариуцсан мэргэжилтэн авч ажилуулах			

2.9 Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар: Хүйтэн усны тоолууртай 16080136

Загвар : LXSC

Тоолуурын тоо: Стандартчилал, хэмжил зүйн газраар баталгаажсан 1 тоолууртай

Суурилуулсан байгууллага, огноо: 2017 оны 01 сарын 18-ны өдөр хүртэл

Баталгаажуулсан байгууллага огноо: 2019 оны 01 дугаар сарын 18-ны өдөр хүртэл

2.10 Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

2.11 Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

Усны экологи эдийн- засгийн үнэлгээг шинчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302 тогтоолоор Галба өөш долоодын.govийн сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326,327 -р тогтоолоор ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож тогтоосон хэмжээгээр “Төсвийн тухай хууль”-ийн 23.8.9 дахь заалт, Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 06 сарын 12-ний өдрийн 51 дугаар тогтоолын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

1м³ усны нөөц ашигласны төлбөр  $3996 \times 15\% \times 0,16 = 95,9$  төг

Усны эх үүсвэр дээр суурилуулан, баталгаажуулсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг сар бүрийн 25-ний дотор тоолуурын баталгаажуулалт хийлгэж төлж барагдуулах.

**Гурав. Талуудын эрх, үүрэг**


3.1 Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1- д заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.


**Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний хэрэгжилтийг 2018 оны 01 дүгээр сард багтаан дүгнэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 4.5.1 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
- 4.5.2 Аль нэг татан буугдсан бол;
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Ус ашиглагчийг төлөөлж:**  
Өмнөговь аймгийн Байгаль орчин,  
аялал жуулчлалын газрын Усны нөөц,  
ашиглалт, хамгаалалт хариуцсан  
мэргэжилтэн  
 \T. Соёлмаа  
Хаяг: Монгол улс, Өмнөговь,  
Удирдлагын ордон 101 тоот  
Харилцах утас: (976) 88555000  
Э-мэйл : [tsoyoloo@yahoo.com](mailto:tsoyoloo@yahoo.com)

**Ус ашиглагчийг төлөөлж:**  
Энержи ресурс ХХК-ий Дэд бүтэц,  
 хөгөөнийн удирдлагын албаны дарга  
Хөгөөн: Ч.Баярсайхан  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Оюубаатар дүүрэг, Сэнтрал тауэр, 16  
давхар  
Харилцах утас: (976) 88118124  
Эмэйл: Bayarsaikhan.ch@mmc.mn